



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 12 сарын 07 өдөр

Дугаар А/547

Мандлговь

Шагнах тухай

Монгол Улсын Засгийн газрын 1997 оны 54 дүгээр тогтоол, Сангийн сайдын 2012 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 239 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.3 дахь заалт, аймгийн Засаг даргын 2017 оны А/251 дугаар захирамжаар шинэчлэгдэн батлагдсан "Аймгийн болон Засаг даргын шагнал олгох журам", аймгийн Засаг даргын Зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн 17 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн "Хүндэт тэмдэг" –ээр дор дурьдсан хүмүүсийг шагнасугай.

- |                         |  |
|-------------------------|--|
| 1. Самдан Цогтбаатар    | Дэрэн сумын Санхүүгийн албаны дарга                              |
| 2. Цэрэндаш Даваа       | Орон нутгийн өмчийн газрын нягтлан бодогч                        |
| 3. Жамбалдорж Сугирмаа  | Татварын улсын байцаагч  |
| 4. Доржсүрэн Эрдэнэболд | Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын нягтлан бодогч |

Хоёр. Дор нэр дурьдсан албан хаагчийг аймгийн Засаг даргын "Жуух бичиг"-ээр шагнасугай. Үүнд:

- |                          |  |
|--------------------------|--|
| 1. Гансүх Нармандах      | Сайнцагаан сумын 6-р цэцэрлэгийн нягтлан бодогч      |
| 2. Шатар Мөнгөнцэцэг     | Татварын улсын байцаагч                              |
| 3. Нанзад Чимэгмаа       | Говийн ирээдүй цогцолбор сургуулийн нярав            |
| 4. Дашдондог Эрдэнэцэцэг | Ус цаг уур, орчны шинжилгээний газрын нягтлан бодогч |

Гурав. Шагналын журмын 5.9-д заасны дагуу Засаг даргын жуух бичгээр шагнагдсан хүмүүсийн дагалдах мөнгөн шагнал 10,000 (арван мянга) төгрөгийг тодорхойлсон байгууллага нь олгохыг тухайн байгууллагын дарга нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488010680

